

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2022.04.25

№ 22/01

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7 дэх заалт, “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон “Богд Банк” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 2- тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Богд банк” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн “хангалттай сайн” гэх дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

2. Энэхүү ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2022.04.25

№ 22/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10 сарын 30-ны №А-276 тоот тушаал, Богд Банкны дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.7.1 дэх хэсгийн заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Богд Банк” ХК-ийн дүрмийн 4, 8 дугаар зүйлд дараах өөрчлөлтийг оруулсугай:

1. “4.2 Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 (тавин сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Банк нь хуульд заасан журмын дагуу хувьцааны хувь хэмжээ, үнэ дүнг өөрчилж болно.” гэснийг “4.2 Банк нь 1600 (нэг мянга зургаан зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 62,500,000 (жаран хоёр сая таван зуун мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.” гэж;

2. 4.3 Банк нь 12,500,000 (арван хоёр сая таван зуун мянган) ширхэг шинээр нэмж зарласан хувьцаатай байна. Банк хуульд заасан журмын дагуу зарласан хувьцааны хэмжээ, үнэ, дүнг өөрчилж болно. гэснийг “4.3 Банк нь нийт 100,000,000 (нэг зуун сая) ширхэг зарласан хувьцаатай байна. Банк зарласан хувьцаанаас энэхүү дүрмийн 4.2-д заасан тооны хувьцааг эргэлтэд оруулахаар гаргасан бөгөөд цаашид зарласан хувьцаанаас гаргах эсэх, хувьцааны нэрлэсэн үнэ, тоог өөрчлөх зэрэг асуудлыг Компанийн тухай болон Банкны тухай хуульд заасан журмын дагуу шийдэж болно.” гэж;

3. Богд банкны дүрмийн 8.3 дахь хэсэгт байгаа “1” гэснийг “3” гэж.

Хоёр. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор “Богд Банк” ХК-ийн дүрэмд дээрхи өөрчлөлтүүдийг оруулан баталж Улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголбанкинд тус тус хүргүүлэх ажиллагааг хийх, холбогдох баримт бичгийг үйлдэх эрхийг “Богд Банк”ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Саруулд даалгасугай.

Гурав. Энэхүү ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2022.04.25

№ 22/03

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж
ТУЗ-н 2022 оны зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6 дэх заалт, “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.8 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлантай танилцаж, хэлэлцсэний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 2- тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Богд банк” ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж энэхүү шийдвэрийн хавсралт 1-д заасан ТУЗ-н 2022 оны зардлын төсвийг Хавсралт-1 дагуу баталсугай.

2. Энэхүү ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2022.04.25

№ 22/09

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.1 дэх хэсэг, 8-р зүйлийн 8.3 дах хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 22 тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1 Лувсанвандангийн Болдхуяг
 - 1.2 Дэмчигжавын Молонжамц
 - 1.3 Жан Торстен Дазер
 - 1.4 Ганбаатарын Саруул
 - 1.5 Эллиот Рован Аукланд
 - 1.6 Базарсадын Ойгонжаргал
- “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.7 Эрдэнийн Бямбажав
 - 1.8 Моеэс Тоомос,
 - 1.9 Жамбалсүрэнгийн Нарантуяа нарыг тус тус томилсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, шийдвэр болон холбогдох бусад баримтыг Монголбанкинд хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Р.Нямцэрэнд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ